



Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах  
зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 21-ний  
өдрийн 23 тоот тогтоолын Хавсралт 1

## **ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНКНЫ НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Энэхүү Худалдаа, хөгжлийн банк (цаашид “Банк” гэх)-ны ногдол ашгийн бодлого (цаашид “Бодлого” гэх)-ын зорилго нь Худалдаа, хөгжлийн банкны хувьцаа эзэмшигчдэд хуваарилах ногдол ашгийн хэмжээ, бодлогыг тодорхойлох, ногдол ашиг хуваарилахтай холбоотой шийдвэр гаргах, энэ талаарх шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, ногдол ашиг төлөх, тайлагнахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү бодлого нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Монголбанк болон бусад эрх бүхий байгууллагаас гаргасан холбогдох дүрэм, журам, заавар, Банкны дүрэмд нийцсэн бөгөөд Банк ногдол ашиг хуваарилах, төлөх үйл ажиллагаанд дээрх хууль, дүрэм, журмуудыг мөрдлөг болгон ажиллана.
- 1.3. Энэхүү ногдол ашгийн бодлогыг Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалтад заасны дагуу Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-өөс боловсруулан баталж, үйл ажиллагаандаа мөрдөнө.

### **Хоёр. Ногдол ашгийн бодлого**

- 2.1. Банк нь хувьцаа эзэмшигчдийн Банканд оруулсан хөрөнгийг Банкны бизнесийн үйл ажиллагаанд зүй зохистой, үр ашигтай захиран зарцуулж, Банк ашигтай ажилласан тохиолдолд хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг олгох, ногдол ашгийн хэмжээг өсгөн зохистой түвшинд байлгах бодлогыг баримтална.
- 2.2. Банк нь Бодлогын 4.2-т заасан нөхцөлүүд бүрэн хангагдсан тохиолдолд хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашгийг жил бүр хуваарилах бодлогыг баримтлан ажиллана.
- 2.3. ТУЗ нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэсэн байна.
- 2.4. Банк цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахдаа ногдол ашгийг бэлэн мөнгө хэлбэрээр эсхүл Банкны дүрэмд заасан хэлбэрээр төлж болно.

### **Гурав. Ногдол ашгийн хэмжээг тодорхойлох**

- 3.1. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр нь Банкны санхүүгийн байдал, үйл ажиллагааны бодит үр дүнд үндэслэгдэнэ.
- 3.2. Ногдол ашиг хуваарилахаас өмнө ашгаас нөөцийн сан, банк хөгжүүлэх сан болон тусгай зориулалтын санг байгуулж болно.
- 3.3. Банкны жилийн санхүүгийн тайланд тусгагдсан татвар төлсний дараах цэвэр ашгаас Банкны нөөцийн сан, банк хөгжүүлэх сан, болон бусад тусгай зориулалтын сангуудад хийгдсэн хөрөнгийн хуваарилалтыг хасаад үлдэх хэсгийг ногдол ашиг болгон хуваарилж болно.

- 3.4. Банкны хуваарилах ногдол ашгийг Банкны тухайн тайлант хугацааны татварын дараах цэвэр ашгийн 40 хүртэл хувиар эсхүл банкны татвар төлсний дараах хуримтлагдсан ашгаас хуваарилж болно.

*/Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 24 тоот тогтоолоор өөрчлөн найруулав./*

#### **Дөрөв. Ногдол ашиг хуваарилах нөхцөл**

- 4.1. Ногдол ашиг хуваарилан олгох эсэх асуудлыг ТУЗ нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Монголбанк болон бусад эрх бүхий байгууллагаас гаргасан холбогдох дүрэм, журам, зааврын хүрээнд шийдвэрлэнэ.
- 4.2. Банк нь ногдол ашиг хуваарилахад Компанийн тухай хуулийн 46-67 дугаар зүйл болон Банкны тухай хуульд заасан нөхцөл, журмыг хангасан байна.
- 4.3. ТУЗ нь ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн бол энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнаж, ногдол ашиг хуваарилж болохгүй байгаа үндэслэл, шалтгаан, хөрөнгө, санхүүгийн тооцоолол, цаашид ногдол ашиг хуваарилах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө танилцуулна.
- 4.4. ТУЗ нь ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бол Банкны тухай хууль болон Монголбанкнаас баталсан журам, зааварт нийцүүлэн ногдол ашиг хуваарилах талаар Монголбанкнаас зөвшөөрөл авах бөгөөд Монголбанкнаас ногдол ашиг хуваарилах зөвшөөрлийг олгосон тохиолдолд ТУЗ-ийн шийдвэрт заасан хугацаанд ногдол ашгийг хуваарилна.
- 4.5. Банк нь нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна.
- 4.6. Банк эргүүлэн худалдаж авсан өөрийн хувьцаанд ногдол ашиг хуваарилахгүй.
- 4.7. ТУЗ нь ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг гаргах бөгөөд уг шийдвэрт дараах зүйлсийг тусгана. Үүнд:
- 4.7.1. Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ;
  - 4.7.2. Ногдол ашгийг төлөх хугацаа;
  - 4.7.3. Төлөх арга, хэлбэр;
  - 4.7.4. Бүртгэлийн өдөр;
  - 4.7.5. Бусад холбогдох асуудал.
- 4.8. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрт заасан бүртгэлийн өдрөөр тасалбар болгосон нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг авах эрх үүсэх бөгөөд Банк энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэнэ.
- 4.9. Давуу эрхийн хувьцаанд хуваарилах ногдол ашгийг тусгайлан байгуулсан сангаас олгож болно.
- 4.10. Хувьцаа эзэмшигч нь хувь хүн бол Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу, аж ахуйн нэгж, хуулийн этгээд бол Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу Банк нь ногдол ашгаас холбогдох татварыг суутгана.

#### **Тав. Тайлагнал ба мэдээлэл хүргүүлэх**

- 5.1. Ногдол ашиг хуваарилах талаар мэдээллийг Банк өөрийн цахим хуудас болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ. Мэдээлэлд нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ, төлөх хугацаа, хэлбэр, арга зам, ногдол ашгийн талаар лавлагаа авах утасны дугаар зэргийг тусгана.

*(Дээрх 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг Худалдаа, хөгжлийн банк ХХК нь хувьцаат компани болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.)*

- 5.2. Ногдол ашиг хуваарилсны дараа Банкны өөрийн хөрөнгө нь 25-иас дээш хувиар багассан тохиолдолд Банк нь ногдол ашгийг шилжүүлсэн өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор зээлдүүлэгчид өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ.
- 5.3. ТУЗ нь ногдол ашиг хуваарилалтын тайланг холбогдох журмын дагуу Санхүүгийн зохицуулах хороо болон бусад эрх бүхий зохицуулах байгууллагад, хувьцаа эзэмшигчдийн дараагийн хуралд заавал тайлагнана.
- 5.4. Ногдол ашиг хуваарилсны дараагийн тайлант хугацаанд энэ талаар Банкны нягтлан бодох бүртгэлийн тайланд холбогдох хуульд заасны дагуу тусгана.
- 5.5. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг нийтэд мэдээлж, хувийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржийн мэдээллийн нэгдсэн санд хүргүүлнэ.  
*(Дээрх 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсгийг Худалдаа, хөгжлийн банк ХХК нь хувьцаат компани болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.)*

. о О о .